



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2025.04.25 № 18

Төрийн байгууллагын удирдах албан  
тушаалтнуудын талаар

Төрийн болон төрийн өмчит байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын орон тоог сүүлийн жилүүдэд нэмэгдүүлж байгаа ч төрийн албаны бүтээмж, ил тод байдал, төрийн үйлчилгээний хүртээмж огт сайжирсангүй, мөн хүнд сурталтай холбоотой асуудлууд ч бүрэн шийдлээ олсонгүй. Энэ нь ажил хийхээсээ илүүтэй зааж, зааварлах албан тушаалтан болох дарга, дэд, тэргүүн, орлогч, зөвлөх, бие төлөөлөгч, захирал, эрхлэгч, удирдах зөвлөлийн гишүүн, менежер, ахлах зэрэг албан тушаалыг шинээр бий болгосон нь зардал огцом өсгөж, улсын төсөвт ихээхэн дарамт учруулах, нөгөө талаас удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны тооны харьцаа алдагдсанаас шийдвэр гаргах шат дамжлага нэмэгдэж, ажлын хурд, бүтээмжийг удаашруулсан сөрөг үр дагавартай, мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байна гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.Төрийн нийт байгууллага болон төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн тоо, тэдгээрийн нийт орон тоо, үүнээс удирдах албан тушаалтнуудын нэршил, тоо, ангилал, зэрэглэл болон цалин, хөлс, холбогдох хэрэглээний зардал, хангамжийн (ажлын байр, унаа, утас, бичиг хэрэг, туслах ажилтны зардал гэх мэт) талаарх судалгааг 2025 оны байдлаар;

2.Удирдах болон гүйцэтгэх, туслах албан тушаалтны тооны харьцаанд сүүлийн 5 жилд дүн шинжилгээ хийсэн эсэх, түүний үр дүнд үндэслэн авсан арга хэмжээний талаар;


3.Төрийн байгууллагуудыг нэгтгэж, давхардсан чиг үүргийг цөөлөх, тэр дундаа удирдах албан тушаалтнуудын тоог бууруулах, бүтэц, хэмнэлтийн бодлого, менежментийн шинэчлэлийн чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, төлөвлөлт, цаашид авах арга хэмжээний талаар.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хавсралт 1 хуудас.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



О.АМГАЛАНБААТАР

2025000025

Судалгаанд хамруулах төрийн болон төрийн өмчит байгууллагууд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч
2. Улсын Их Хурал
3. Ерөнхий сайд
4. Шадар сайд
5. Засгийн газар
6. Сайд
7. Яам
8. Агентлаг
9. Элчин сайдын яам
10. Үндэсний хороод
11. Хүрээлэн
12. Сан
13. Хувь нийлүүлсэн нийгэмлэг
14. Тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд
15. Аймаг, нийслэл, дүүрэг, сум, баг, хороо, тосгоны ИТХ, ЗДТГ
16. Төрийн байгууллага
17. Төлөөлөн удирдах зөвлөл
18. Төрийн өмчит байгууллага
19. Улсын төсөвт үйлдвэрийн газар
20. Аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газар
21. Орон нутгийн өмчит байгууллагууд.

Жагсаалтад дурдагдаагүй ч асуулгын агуулгад хамаарах төрөөс санхүүжилт авдаг бусад байгууллагыг хамруулна.